

Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн талаарх зарим асуудал

Б. Болор
ОХУ-ын Дорнод Сибирийн Технологийн
Их Сургууль, докторант

Гэр бүлийн гишүүд нь хөдөлмөрлөхгүйгээр өрхийн орлогыг бий болгох ямар ч боломж байдаггүйтэй адил хөдөлмөр эрхлэлтийг дэмжихгүйгээр улс орны эдийн засгийн хөгжлийг хурдасгах, хүн амын орлогыг нэмэгдүүлэх, эрэлт хэрэгцээг өсгөх, иргэдэд ирээдүйдээ итгэн сэтгэл өөдрөг амьдруулах ямар ч боломжгүй болох билээ.

2005 онд хөдөлмөрийн зах зээлд гарч буй үндсэн өөрчлөлт, Монгол Улсын Засгийн Газрын үйл ажиллагааны Мөрийн хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлого явуулах замаар ажилгүйдлийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлснээр 2005 онд ажилгүйдлийн түвшин 3.3 хувь болсон ба 2001 онтой харьцуулахад 28.3 хувиар буурсан байна. Сүүлийн 5 жилийн байдлаар авч үзвэл, ажлын байрны захиалгын тоо 44.4 хувь, ажилд зуучилсан хүний тоо 74.9 хувь, мэргэжлийн сургалтанд хамрагдсан хүний тоо 64.5 хувиар тус тус нэмэгдэж, нийтийг хамарсан ажилд хамрагдсан хүний тоо 2 дахин өсчээ. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 2005 онд нийт 3879.6 сая төгрөгийн хөрөнгө төвлөрүүлсэн байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлсэн нийт хөрөнгийн 96.2 хувь буюу 3734.1 сая төгрөгийг гадаадаас ажиллах хүч авч байгаа байгууллагуудын ажлын байрны төлбөрөөс, 3.0 хувь буюу 114.5 сая төгрөгийг эсжиг зээлийн хүүгийн орлогоос, 0.4 хувь буюу 16.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 0.4 хувь буюу 14.6 сая төгрөгийг бусад эх үүсвэрийн орлогоос тус тус бүрдүүлжээ.

Манай улсад зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн жилүүдэд нийтийг хамарсан ажил санхүү, зохион байгуулалтын шалтгааны улмаас төдийлөн хөгжсөөгүй байна. Мөн нийтийг хамарсан ажил зохион байгуулах нь хуулийн дагуу хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлогын хүрээнд заавал хийх ёстой ажлын нэг болсон байна.

Өнөөдөр нийгмийн хамгийн эмзэг асуудал болох ядуурал, ажилгүйдэл нь зөвхөн Засгийн газрын үүрэг гэсэн ойлголтыг өөрчилж, энэ чиглэлд орон нутагт эрх шилжүүлэх, хариуцлага хүлээлгэх тогтолцоог судалж, хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор гарч байна. Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлогыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн болон санхүүгийн нөөц боломж, бүтэц зохион байгуулалт бүрэлдэн тогтоож байгаагийн үр дүнд төв орон нутаг дахь хөдөлмөр, халамжийн үйлчилгээний үйл ажиллагаа өргөжин, нэр хүнд өсч байна.

Хөдөлмөр эрхлэлтийн дүнд бий болсон баялгаар нийгэм, хувь хүний эрэлт хэрэгцээ хангагдана. Гэр бүлийн гишүүд нь хөдөлмөрлөхгүйгээр өрхийн орлогыг бий болгох ямар ч боломж байдаггүйтэй адил хөдөлмөр эрхлэлтийг дэмжихгүйгээр улс орны эдийн засгийн хөгжлийг хурдасгах, хүн амын орлогыг нэмэгдүүлэх, эрэлт хэрэгцээг өсгөх, иргэдэд ирээдүйдээ итгэн сэтгэл өөдрөг амьдруулах ямар ч боломжгүй болох билээ.

Аливаа нийгэм үр ашигтай хөдөлмөр эрхлэлтийн төлөө байдаг бөгөөд үр ашигтай хөдөлмөр эрхлэлтийг зах зээлийн нөхцөлд бодлогоор зохицуулж хэрэгжүүлэхэд “Хүн

амын хөдөлмөр эрхлэлтийн тухай“ хууль онцгой үүрэгтэйг зах зээл хөгжсөн орнуудын туршлага харуулж байна.

Манай улсад хэрэгжүүлж байгаа Хөдөлмөр эрхлэлтийн хуулиудад зах зээлийн хөдөлмөрийн харилцааны болон хөдөлмөр эрхлэлтийн үндсэн зарчмуудыг тодорхойлсон байна. Үүнд:

Нэг дэх зарчим: албадлагын, заавал гүйцэтгэх үүргийн хөдөлмөрийг хориглож, хөдөлмөрт болон хөдөлмөр эрхлэлтэд эрх чөлөөт байдлыг хангана. Нийгмийн хөдөлмөрт оролцох, эс оролцох сонголт хийх тэргүүлэх эрх Монгол улсын иргэнд нээлттэй болов.

Хоёр дахь зарчим: зах зээлийн нөхцөлд ажилгүйдэл байх нь бодит зүйл учраас ажилгүйчүүдийг хөдөлмөрт татан оролцуулах болон хөдөлмөр эрхлэхэд материаллаг дэмжлэг туслалцаа үзүүлэх, ажилгүйдлээс хамгаалах, хөдөлмөрлөх эрхийг хангах нөхцөл орчинг бий болгох явдал юм.

Монгол улсын Үндсэн хуулийн хоёрдугаар бүлгийн 16 дугаар зүйлийн 4 дүгээр заалтанд: “Монгол Улсын иргэн ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцлөөр хангуулах, цалин хөлс авах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй” гэж заасан байдаг. Энэ заалтаас үзэхэд Монголын иргэн эдийн засгийн аль ч салбарт, ямар ч хэлбэрийн хөдөлмөр эрхлэх бүрэн эрхтэйг хуульчлан зааж өгчээ.

Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжих эхний үед ажилгүйдэл их хэмжээтэй болж, улс төрч, судлаач, эдийн засагчдын анхааралд хөдөлмөр эрхлэлтийн асуудал чухал байр суурийг эзлэх болов. Зах зээлийн эдийн засгийн тогтолцоотой оронд хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийг гурван бүлэгт хувааж үздэг. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт: Хамгийн том бүлэг болох хөлсний ажиллах хүч буюу ажиллах хүчээ худалдаж буй ажилчин хүмүүс юм. Зах зээлийн эдийн засгийн хөгжилтэй орнуудад энэ бүлэг хүмүүс нийт ажиллах хүчний 80-85 хувийг хамардаг. Манай орны хувьд энэ үзүүлэлт 2005 оны байдлаар 62.1 хувь байна.

Хоёрдугаар бүлэгт: Ажил олгогч эзэд, банк, санхүүгийн байгууллагын эзэд болон бусад хөлсний ажиллах хүчин ашигладаг хүмүүс хамрагддаг.

Гуравдугаар бүлэгт: Хөлсний ажиллах хүчин хэрэглэдэггүй, хувиараа аж ахуй, хөдөлмөр эрхлэн бүтээгдэхүүн хийж, үйлчилгээ явуулдаг хүмүүс хамаарагддаг.

Зах зээлийн өндөр хөгжилтэй орнуудад ашиглагдаж буй хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг зарим судлаачид үндсэн гурван загварт авч үзсэн байдаг. Үүнд:

Европын загвар: хөдөлмөрийн бүтээмж дээшлэхэд ажиллагсдын тоог цөөрүүлж, тэгснээр ажиллагсдын орлогын өсөлтийг санал болгоно. Тийм бодлого баримтлагчид олон тооны ажилгүйчүүдэд өндөр үнэтэй тэтгэмжийн тогтолцоо урьдчилан ээхдэг байна.

Скандиновын загвар: хөдөлмөрийн хөлсний дундаж нөхцлөөр төрийн секторт ажлын байр бүтээх замаар бодит байдал дээр бүх хөдөлмөрчдийг ажлын байраар хангахад үндэслэдэг. Энэ нь хомсдлын үеийн үйлдвэрлэлийн уналтад өртөж, түүний үр дагавар хоморголон халагдалт болоход үйлчлэх төрийн хөрөнгөд тооцоолсон бодлого юм.

Америкийн загвар: эдийн засгийн идэвхтэй хүн амын нэлээд хэсэгт нь өндөр бүтээмж үл шаардах ажлын байр бүтээхэд баримжаалдаг юм. Тийм хандлагын үед ажилгүйдэл

хэлбэрийн төдий буурдаг ч гэсэн доогуур орлоготой хүмүүсийн тоо нэмэгдсээр байдаг.

Аль ч загвар ашиглах нь макро болон микро түвшинд хөдөлмөр эрхлэлтийн бодлогод нөлөөлдөг. Хөдөлмөр эрхлэлтийн макро түвшний бодлогын шинэ хандлага нь хөдөлмөрийн зах зээлийн уян хатан байдалд дэм үзүүлж, ажиллах хүчний зардлыг бууруулж, нийгмийн хөтөлбөрүүдийг зарим талаар багасгахад хүргэдэг. Микро түвшинд долоо хоногийн ажлын үргэлжлэх хугацааг сунгах, хөдөлмөрийн хөлсний өсөлтийг тогтоон барих, бүрэн бус хөдөлмөр эрхлэлтийн янз бүрийн хэлбэрүүдийг илүү өргөн ашиглах бодлого явуулдаг.

Хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг эрхлэн хөтлөх арга хэрэгслийн идэвхтэй, идэвхгүй гэсэн хоёр үндсэн хувилбар өнөөдөр үйлчилж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн идэвхтэй бодлого : ажилгүйдлийг бууруулах зорилгоор төрөөс явуулж буй эрх зүй, зохион байгуулалт, эдийн засгийн арга хэмжээний нийлмэл юм. Энэ нь ажлын байруудыг хадгалах, ажилтнуудыг халагдахаас сэргийлэх, хүмүүсээ мэргэжлээр нь бэлтгэж, дахин сургах, ажил хайж байгаа хүмүүсийн мэргэжлийг дээшлүүлэх; ажлын байр идэвхтэй эрж, сонголт хийх; ажлын байр шинээр бүтээхэд санхүүжилт хийх; нийтийг хамарсан зохион байгуулалттай ажлыг зохион байгуулахтай холбоотой арга хэмжээнүүдийг авч үздэг.

Хөдөлмөр эрхлэлтийн идэвхтэй биш бодлого: ажилгүйчүүдэд тэтгэмж олгох, төрийн хөдөлмөр халамжийн газраас ажлын байр сонгох жирийн үйлчилгээ үзүүлэхийг хараандаа авах төдий хүрээний үйл ажиллагаа юм. Энэ бодлого нь зөвхөн бие дааж хөдөлмөр зохицуулах боломж өндөр, хөдөлмөрийн зах зээл болон ажиллах хүч нийтдээ уян хатан зохицуулалттай байсан нөхцөлд зөв болохоо харуулна. Харин үүнээс эсрэг тохиолдолд хөдөлмөрийн зах зээлийн идэвхгүй бодлогоор барих тохируулгууд нь өлбөгөр болж, нөхцөл байдлыг бүр дордуулдаг гэж үзэж болно. Идэвхтэй бодлого үгүйлэгдвэл хөдөлмөр , халамжийн үйлчилгээний хэлтсийн үндсэн чиг үүргүүд ихээхэн хумигдаж, түүнийг нийгмийн тэтгэмжийн жирийн контор болгож хувиргана.

2005 онд хөдөлмөрийн зах зээлд гарч буй үндсэн өөрчлөлт, Монгол Улсын Засгийн Газрын үйл ажиллагааны Мөрийн хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлого явуулах замаар ажилгүйдлийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлснээр 2005 онд ажилгүйдлийн түвшин 3.3 хувь болсон ба 2001 онтой харьцуулахад 28.3 хувиар буурсан байна.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтэнд нийцүүлэн ажил олгогч, мэргэжлийн түр сургалтын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажилласнаар ажилгүй иргэдийг ажил олгогчоос ирүүлсэн сул чөлөөтэй ажлын байранд зуучлах, мэргэжлийн түр сургалтад хамруулах, жижиг зээл олгосноор ажлын байр шинээр бий болгох, нийтийг хамарсан ажил зохион байгуулж ажилгүй иргэдийг түр ажлын байраар хангах, хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэрт гарсан иргэдэд нөхөн олговор олгох, ажлаас чөлөөлөгдөж ажилгүй болсон иргэдэд тэтгэмж олгох, нэг жилээс дээш хугацаагаар Хөдөлмөр Халамж Үйлчилгээний

Хэлтэст бүртгэлтэй байсан ажилгүй иргэдийг ажилд авсан ажил олгогчийг дэмжих зэрэг хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх үйлчилгээ, арга хэмжээг амжилттай хэрэгжүүлсэн байна.


Хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үзүүлэлтүүдийг сүүлийн 5 жилийн байдлаар дараахь хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1. Хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үзүүлэлтүүд


| Үзүүлэлт | 2001 | 2002 | 2003 | 2004 | 2005 | Зөрүү (2004-2005) | Харьцуулсан хувь | | | |
|---|-------|-------|-------|-------|-------|----------------------|------------------|-----------|-----------|-----------|
| | | | | | | | 2005/2001 | 2005/2002 | 2005/2003 | 2005/2004 |
| Бүртгэлтэй ажилгүй иргэн | 40283 | 32020 | 34963 | 35571 | 32925 | -2646 | 81.7 | 102.8 | 94.2 | 92.6 |
| Нэмэгдсэн ажилгүй иргэн | 33738 | 45375 | 62372 | 58485 | 56233 | -2252 | 166.7 | 123.9 | 90.2 | 96.1 |
| Хасагдсан ажилгүй иргэн | 31924 | 49418 | 60170 | 56189 | 58890 | 2701 | 184.5 | 119.2 | 97.9 | 104.8 |
| Ажилгүйдлийн түвшин | 4.6 | 3.4 | 3.5 | 3.7 | 3.3 | -0.3 | 71.7 | 97.1 | 94.3 | 89.2 |
| Ажлын байрны захиалгын тоо | 30226 | 32285 | 35151 | 39023 | 43664 | 4641 | 144.5 | 135.2 | 124.2 | 111.9 |
| Ажилд зуучлан оруулсан хүний тоо | 25693 | 35187 | 38640 | 38445 | 44955 | 6510 | 175.0 | 127.8 | 116.3 | 116.9 |
| Мэргэжлийн сургалтанд хамрагдсан хүний тоо | 11846 | 16918 | 21008 | 22265 | 19493 | -2772 | 164.6 | 115.2 | 92.8 | 87.5 |
| Нийтийг хамарсан ажилд хамрагдсан хүний тоо | 8864 | 13447 | 19977 | 18711 | 17877 | -834 | 201.6 | 132.9 | 89.5 | 95.5 |
| Ажилгүйдлийн тэтгэмжинд хамрагдсан иргэд | 5337 | 4869 | 6002 | 6340 | 7113 | 773 | 133.3 | 146.1 | 118.5 | 112.2 |

Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлогын хүрээнд хийгдсэн арга хэмжээнүүдийг дараахь байдлаар харуулав.

Зураг 1. Ажлын байрны захиалгын тоо



Зураг 2. Ажилд зуучилсан хүний тоо



Сүүлийн 5 жилийн байдлаар авч үзвэл, ажлын байрны захиалгын тоо 44.4 хувь, ажилд зуучилсан хүний тоо 74.9 хувь, мэргэжлийн сургалтанд хамрагдсан хүний тоо 64.5 хувиар тус тус нэмэгдэж, нийтийг хамарсан ажилд хамрагдсан хүний тоо 2 дахин өссөн байдалтай байна. Ажилгүйчүүдэд түр ажил эрхлэх боломж олгодог чухал хэлбэрийн нэг нь нийтийг хамарсан ажил зохион байгуулах явдал юм. Энэ хэлбэр нь АНУ-д 30-аад онд нийтийг хамарсан ажилгүйдэлтэй тэмцэхэд, ажилгүйдлийн түвшин өсөх үед бусад орнуудад тодорхой үүрэг гүйцэтгэсэн байна. АНУ-ын Ерөнхийлөгч Рузвельт нийтийг хамарсан ажилд ихээхэн анхаарал тавьж байжээ. АНУ-д энэ зорилгоор тусгай татвар бий болгож, нийтийг хамарсан ажлын санг байгуулжээ.




Манай улсад зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн жилүүдэд нийтийг хамарсан ажил санхүү, зохион байгуулалтын шалтгааны улмаас төдийлөн хөгжөөгүй байна.


Дээрх тоо баримтаас үзвэл өнөөдөр нийтийг хамарсан ажил зохион байгуулах нь хуулийн дагуу хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлогын хүрээнд заавал хийх ёстой ажлын нэг болсон нь харагдаж байна. Энэ ажилд төв орон нутаг дахь хөдөлмөр, халамжийн үйлчилгээний үйл ажиллагаа гол чухал үүргийг гүйцэтгэх болжээ.

Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлогыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн болон санхүүгийн нөөц боломж, бүтэц зохион байгуулалт бүрэлдэн тогтож байгаагийн үр дүнд төв орон нутаг дахь хөдөлмөр, халамжийн үйлчилгээний үйл ажиллагаа өргөжин, нэр хүнд өсч байна.

Хөдөлмөр Халамж Үйлчилгээний Хэлтэсээр үйлчлүүлсэн хүний тоог сүүлийн 5 жилийн байдлаар авч үзвэл 2005 онд 299666-д хүрч өмнөх онуудтай харьцуулахад 1.3-3.7 дахин өссөн байна (Зураг 5).




Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлого явуулахад 2001 оны 4 дүгээр сард батлагдсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, уг хуульд заасны дагуу байгуулсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан ихээхэн түлхэц үзүүлж байна.



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 2005 онд нийт 3879.6 сая төгрөгийн хөрөнгө төвлөрүүлсэн байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлсэн нийт хөрөнгийн 96.2 хувь буюу 3734.1 сая төгрөгийг гадаадаас ажиллах хүч авч байгаа байгууллагуудын ажлын байрны төлбөрөөс, 3.0 хувь буюу 114.5 сая төгрөгийг жижиг зээлийн хүүгийн орлогоос, 0.4 хувь буюу 16.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 0.4 хувь буюу 14.6 сая төгрөгийг бусад эх үүсвэрийн орлогоос тус тус бүрдүүлсэн байна.

2005 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд давхардсан тоогоор 136.6 гаруй мянган хүн хамрагдаж тэдэнд 3220.3 сая төгрөгийг зарцуулжээ.



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг аль болохоор ажлын байр бий болгох арга хэмжээнд ялангуяа, мэргэжлийн сургалт, жижиг зээлийн арга хэмжээнд зарцуулах чиглэлийг баримталж байна.

2001 оноос “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” болон “Гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай” хуулиудыг батлан хэрэгжүүлэх болсноор хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн үйлчилгээг зах зээлийн нөхцөл байдалд нийцүүлэн хэрэгжүүлэх эрх зүй, эдийн засгийн орчин үндсэндээ бүрдсэн гэж үзэж болно.

Эдгээр хуулиуд хэрэгжих болсноор хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний санхүүгийн эх үүсвэр шийдвэрлэгдэж, түүнийг хэрэгжүүлэх төв, орон нутгийн албадын бүтэц, үйл ажиллагаа тогтворжин, чадавхижиж, үйлчилгээний цар хүрээ өргөжсөн бөгөөд ажиллах хүчний экспорт, импортын стандарт, квотыг тогтоох, түүнийг хэрэгжүүлэх зохицуулалтын механизм төлөвшиж эхэлсэн ба хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд 7.9 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. 2001 онд “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хуулийг УИХ батлан гаргаж, хөдөлмөр эрхлэлтийн албадыг улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан байгуулах, уг санд улсын төвлөрсөн төсвийн орлогын 0.3 хувиас багагүй хөрөнгө хуваарилж байхаар шийдвэрлэсэн нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг сайжруулахад чухал нөлөө үзүүлж байна.

Сүүлийн 5 жилд хөдөлмөрийн зах зээл зохих ёсоор зах зээлийн харилцаанд шилжиж үйлчилгээ нь өргөжиж эдийн засгийн үр дүнгээ өгч эхэлсэн байна. 2004 оныг хууль гарахын өмнөх жил 2000 онтой харьцуулахад хөдөлмөр эрхлэлтийн албанд ирсэн сул чөлөөтэй ажлын байрны захиалга 2 дахин, ажилд зуучлан оруулсан хүний тоо 2.6 дахин, мэргэжлийн сургалтанд хамрагдсан хүний тоо 4 дахин өссөн байна.

Дээрх байдлаас дүгнэж үзвэл, сүүлийн 5 жилд хөдөлмөрийн зах зээл зохих ёсоор зах зээлийн харилцаанд шилжиж үйлчилгээ нь өргөжиж эдийн засгийн үр дүнгээ өгч эхэлж байна. Хөдөлмөр эрхлэлтийн салбарт тодорхой ололт амжилт байгаа боловч боловсронгуй болгох шаардлагатай нэлээд асуудлууд байна.

Манай улсад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих эрх зүй, эдийн засгийн орчин нөхцөл бүрэлдэн тогтсон боловч ажилгүйдэл, ядуурал нийгмийн хамгийн эмзэг асуудал байсан хэвээр байна.

Өнөөдөр нийгмийн хамгийн эмзэг асуудал болох ядуурал, ажилгүйдэл нь зөвхөн Засгийн газрын үүрэг гэсэн ойлголтыг өөрчилж, энэ чиглэлд орон нутагт эрх шилжүүлэх, хариуцлага үүрүүлэх тогтолцоог судалж хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор гарч байна.

Ашигласан материал

А.И. Рофе, А.Л. Жуков, 1999. Теоретические основы экономики и социологии труда, Москва

В.Н. Чапек, Д.В. Максимов, 2005. Экономика труда, Ростов - на Дону

Л. Лханям, Л.Саран, 2004. Хөдөлмөрийн эдийн засаг, Улаанбаатар

Монгол Улсын Их Хурал, 1992. Монгол Улсын Үндсэн Хууль, Улаанбаатар

Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, 2004. Монголын Хүний хөгжлийн илтгэл 2003: Хот хөдөөгийн хүний хөгжлийн ялгаатай байдал, Улаанбаатар

МҮЭ-үүдийн Холбооны дэргэдэх Хөдөлмөрийн дээд сургууль, 2004. Хөдөлмөрийн зах зээл, Улаанбаатар

Н. Содномдорж, 2000. Орчин үеийн хөдөлмөрийн эдийн засаг, Улаанбаатар

НХХЯ, Хөдөлмөр, Халамжийн Үйлчилгээний Газар, 2005. Хөдөлмөр, "Халамжийн үйлчилгээний газрын 2005 оны тайлан", Улаанбаатар

"Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын удирдах ажилтны зөвлөлгөө"-н дээр Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ц. Баярсайханы хэлсэн үгнээс

Үндэсний Статистикийн Газар, 2005. Монгол Улсын Статистикийн эмхтгэл 2004. Улаанбаатар